1. Багш “25 MB хэдэн KB болох вэ?” гэсэн бодлогыг самбарт бичжээ. Сурагч Д бодлогын нөхцөлийг уншиж ойлгоод, тооцоолол хийж зөв хариуг гаргав.
   Сурагч Д-гийн энэ үйлдэл мэдээллийн процессын аль үе шатанд хамаарах вэ?

   A. боловсруулах
   B. дамжуулах
   C. хүлээн авах
   D. хадгалах

2. Сурагч Д 48 хуудастай ном уншиж байгаа ба одоогоор 35 хуудсыг уншсан бол хоёртын кодын тусламжтайгаар үлдсэн хуудасны тоог сонгоно уу.

   A. 1101 B. 1011 C. 1110 D. 1001

3. MS Word программ дээр бичсэн илтгэлийн сэдвээ хэдэн бит болохыг мэдэхийг хүсэв. Үг хоорондын зай болон тэмдэгт бүр нь нэг байт гэж үзвэл хэдэн бит болох вэ?

   8 бит=1 б (байт)

   *Би сагс тоглох дуртай*

   A. 29 бит
   B. 21 бит
   C. 168 бит
   D. 146 бит

4. Дараах зураг нь компьютерын санах ойд хэдэн байтаар дүрслэгдэх вэ?

   *1 дөрвөлжин нүд = 1 бит*

   *8 бит=1 б (байт)*



   A. 80
   B. 10
   C. 40
   D. 640

5. Сурагч Д 2 GB хэмжээтэй бие даалтаа Facebook Messenger ашиглан илгээхэд дараах алдааны мэдээлэл гарчээ. Messenger нь 100 MB хүртэл хэмжээтэй файл илгээхийг зөвшөөрдөг бол сурагчийн файл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэдэн MB-аар хэтэрсэн бэ?




   A. 1.94 MB
   B. 194 MB
   C. 1.9 GB
   D. 1948 MB

6. Сурагч Д багшийнхаа компьютер дээрээс ангийнхаа зургийн цомгийг файлаар хуулж авахаар болов. Түүнд хамгийн багадаа хэдэн гегабайт /GB/ хэмжээтэй зөөврийн хуруу диск хэрэг болохыг сонгоно уу.




   A. 2 GB
   B. 4 GB
   C. 3700 GB
   D. 4000 GB

7. Сурагч Д дараах файлуудыг нэг төхөөрөмжид хадгалах шаардлагатай болжээ. Файлуудын нийт хэмжээг тооцоолж, хадгалахад багтаамжийн хувьд хамгийн тохиромжтой төхөөрөмжийг сонгоно уу.

| Файлын төрөл | Тоо ширхэг | Хэмжээ | Нийт хэмжээ |
|---|---|---|---|
|   | 1 | 1.2 GB | ? |
|   | 7 | 5.0 MB | ? |
|   | 2 | 2048 KB | ? |
|   | 10 | 1024 KB | 10.0 MB |

   A. CD – 700 MB
   B. DVD – 4.7 GB
   C. SD карт - 4 GB
   D. Флаш диск 2 GB

8. Сурагч Д MS Word программ дээр усны зохистой хэрэглээний талаар дүрснүүд ашиглан зураг зурахаар төлөвлөжээ. MS Word программд дүрс оруулах командыг сонгоно уу.



   A. [Insert] → [Illustrations] → [Pictures]
   B. [Insert] → [Shape Format] → [Shape]
   C. [Insert] → [Illustrations] → [Shapes]
   D. [Insert] → [Media] → [Shapes]

9. Сурагч Д MS Word программ дээр хүснэгт үүсгэжээ. Өнгөөр будагдсан нүдний хаяг буюу мөр, баганын зөв тодорхойлолтыг сонгоно уу.



A. Улаан - 1 дүгээр багана, 2 дугаар мөр
Ногоон - 2 дугаар багана, 3 дугаар мөр
Шар - 3 дугаар багана, 2 дугаар мөр

B. Улаан - 1 дүгээр багана, 3 дугаар мөр
Ногоон - 2 дугаар багана, 2 дугаар мөр
Шар - 2 дугаар багана, 4 дүгээр мөр

C. Улаан - 3 дугаар багана, 1 дүгээр мөр
Ногоон - 4 дүгээр багана, 2 дугаар мөр
Шар - 2 дугаар багана, 4 дүгээр мөр

D. Улаан - 1 дүгээр багана, 3 дугаар мөр
Ногоон - 2 дугаар багана, 4 дүгээр мөр
Шар - 4 дүгээр багана, 2 дугаар мөр

10. Сурагч Д MS Word программ дээр 5 хуудас бүхий ангийн танилцуулгыг бэлтгэв. Тэр зөвхөн 3 дугаар хуудсыг хоёр хувь, хэвтээгээр хэвлэх шаардлагатай болов. Баримтыг хэвлэх зөв тохиргоог сонгоно уу.

A.




B.




C.




D.



11. Сурагч Д MS Word программ дээр дараах хүснэгтийг оруулж хэлбэржүүлсэн бол ашигласан командуудыг сонгоно уу.

<table>
<tr><td rowspan="6">Усны хэрэглээ</td><td>Гараг</td><td>Үйл ажиллагаа</td><td>Хэрэглэсэн ус /л/</td></tr>
<tr><td>Даваа</td><td>Гар нүүр угаах</td><td>6</td></tr>
<tr><td>Мягмар</td><td>Аяга, таваг угаах</td><td>12</td></tr>
<tr><td>Лхагва</td><td>Усанд орох</td><td rowspan="2">30</td></tr>
<tr><td>Пүрэв</td><td>Хувцас угаах</td></tr>
<tr><td>Баасан</td><td>Аяга, таваг угаах</td><td>12</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| A. | Shading | Split Table | Text Direction | **B** Bold |
| B. | Cell Margins | **B** Bold | Split Cells | Pen Color |
| C. | Text Direction | Merge Cells | Shading | *I* Italic |
| D. | Merge Cells | Draw Table | *I* Italic | Text Direction |

12. Paint.NET программ дээр давхаргууд (layers) ашиглахын гол давуу талыг сонгоно уу.




A. Зургийн хэсгүүдийг тус тусад нь засварлаж, бусдад нь нөлөөлөхгүйгээр өөрчлөлт хийдэг.
B. Зургийн файлын хэмжээг автоматаар багасгаж, компьютерын хурдыг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг.
C. Зургийн өнгө болон нягтралыг сайжруулж, илүү тод зураг, дүрс үүсгэх боломжийг олгодог.
D. Зургийн бүх хэсгийг нэгтгэж, хэсэгчлэн засвар хийх боломжийг бүрэн хязгаарладаг.

13. Сурагч Д Paint.NET программ дээр дараах зургуудыг давхарга үүсгэн нэгтгэн боловсруулах үед байшингийн цагаан дэвсгэрийг арилгах шаардлагатай болов. Дэвсгэрийг идэвхжүүлэх хэрэгслийг сонгоно уу.




A.  B.  C.  D. 

14. Paint.NET программ дээр зурсан дүрсүүдийн давхцалыг ажиглан, давхаргуудын зөв дараалгыг сонгоно уу.



A.




B.




C.




D.



15. Сурагч Д Paint.NET программ дээр зураг-1-ийг зураг-2 шиг болгохын тулд загасыг олшруулж, заримыг нь эсрэг чиглэлтэй болгох шаардлагатай болов. Үүнийг хийхийн тулд аль цэсийн ямар командуудыг ашиглахыг сонгоно уу.




A. Layers → Flip Horizontal
   Image → Flip Vertical
B. Layers → Duplicate layer
   Layers → Flip Horizontal
C. Layers → Duplicate layer
   Layers → Flip Vertical
D. Layers → Duplicate layer
   Image → Flip Horizontal

16. MS PowerPoint программын бусад программаас ялгарах нэг онцлог бол объект болон слайдад хөдөлгөөн оруулах боломж юм. Тэгвэл слайд хоорондын шилжилтийн хөдөлгөөнийг тохируулахдаа ямар цэсийн командыг ашигладаг вэ?

A. [Insert]→[Illustrations]→[3D Models]
B. [Transitions]→[Transition to This slide]→[Fade]
C. [Animations]→[Animation]→[Wheel]
D. [Design]→[Themes]→[Theme]

17. MS PowerPoint программд слайд дээр дурын хэсэгт бичвэр оруулахын тулд ашиглах командыг сонгоно уу.

A. [Home] → [Action]
B. [Insert] → [Text Box]
C. [Insert] → [Add Title]
D. [Home] → [Object]

18. MS PowerPoint программ дээр дараах тохиргоог хийсэн тохиолдолд тухайн объектын хөдөлгөөн хэрхэн ажиллах вэ?




A. Объект хулганын даралтаар эхэлж, 4 секундийн турш хөдөлнө.
B. Объект өмнөх хөдөлгөөнтэй зэрэг автоматаар эхэлж, 4 секундийн турш хөдөлнө.
C. Объект 4 секунд хүлээсний дараа автоматаар эхэлж, 4 секундийн турш хөдөлнө.
D. Объект өмнөх хөдөлгөөн дууссаны дараа автоматаар эхэлж, 4 секундийн турш хөдөлнө.

19. Сурагч Д MS PowerPoint программ дээр дараах бичвэрийг хэлбэржүүлсэн бол ашигласан командуудыг сонгоно уу.




| | | | | |
|---|---|---|---|---|
| A. | Shape Effects | Animation Pane / Play From / 1 TextBox 5: Ta... | Selection Pane | Shape Fill |
| B. | Text Outline | Shape Fill | Shape Outline | Shape |
| C. | Shape Fill | Text Fill | Text Outline | Animation Pane / Play From / 1 TextBox 5: Ta... |
| D. | Text Outline | Fade | Shape Outline | Text Effects |

20. Сурагч Д Мэдээллийн технологийн хичээлийн бие даалтаа багаар гүйцэтгэх шаардлагатай болов. Тэрээр:
    1. Багийн гишүүдтэй нэгэн зэрэг шуурхай холбогдож, хэлэлцүүлэг хийх
    2. Бэлтгэсэн файлаа бусдадаа илгээх
    3. Хэлэлцүүлгийн бичлэгийг дараа нь дахин үзэх
    4. Асуулт, санал бодлоо чат, комментоор солилцох

Дээрх бүх шаардлагыг хангах цахим харилцааны хэрэгслүүдийг сонгоно уу.

A. Видео хурал, цахим шуудан, нийгмийн сүлжээ
B. Видео хурал, үүрэн холбоо, нийгмийн сүлжээ
C. Цахим шуудан, нийгмийн сүлжээ, мэдээлэл түгээх сайт (WWW)
D. Суурин холбоо, цахим яриа (чат), үүрэн холбоо